



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

С.Зоригийн гудамж 2, 1 дүгээр хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас: (976) 7711 1027, Цахим шуудан: info@fchm.edu.mn

2026.05.25 № 1/1114

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэлд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-д заасны дагуу үнийн санал ирүүлнэ үү.

Үнийн саналыг 2026 оны 05 дугаар сарын 28-ны 11.00 цаг хүртэл хүлээн авна.

Мэйл хаяг: procurement@fchm.edu.mn

Хаяг: УНТЭ-ийн 1 давхар 103 тоот

Хавсралт 1 хуудастай.

Жич: Бэлэн байгаа эмнэлгийн хэрэгсэлд үнийн санал ирүүлнэ үү.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



П.АНХТУЯА

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий
захирлын 2026 оны 05 дугаар сарын 05 -ны
өдрийн 11114 дугаар албан бичгийн хавсралт



Эмнэлгийн хэрэгсэл

№	Эмнэлгийн хэрэгслийн нэршил	Хэмжээ	Техникийн тодорхойлолт	Тоо ширхэг
1	2 хөндийн пейсмерек төхөөрөмж /MRI боломжтой/		Электрод холболт нь IS1 стандарттай, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) боломжтой, MRI-д оношилгоонд зориулсан тохиргоотой. Тосгуурын фибрилляцийг үүсэх үед дарангуйлан арилгах горимтой, пейсмерек хамааралтай болон хамааралгүйгээр аюултай хэм алдагдал үүссэнийг бүртгэн авч 2 ба түүнээс дээш минутын бичлэгийг хадгалдаг байх; Үйлдвэрийн тохиргоогоор ажиллах хугацаа 12 ба түүнээс дээш жил, үйлдвэрлэлийн баталгаат хугацаа 5 ба түүнээс дээш жил, мэдрэг байдлын тохиргоо болон цочроох байдлын тохиргоо нэг туйлт, хоёр туйлт боломжтой байх, баруун тосгуур, ховдлыг цочроох вольтын хэмжээг төхөөрөмж өөрөө автоматаар шалгаж, өөрийгөө тохируулах чадвартай байх, ховдлын өөрийн агшилтыг дэмжих алгоритмтай, зүрхний суурь цохилтын тоо ба пейсмерекээр удирдаж эхлэх суурь цохилтын тоог өөр өөрөөр тохируулах боломжтой байх, PSA шалгагчтай байх.	2
2	Тосгуурын электрод		Шулуун хэлбэртэй, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) хийх боломжтой, хэмжээ 6F-ээс ихгүй, 53 см дээш 3 төрлийн уртын сонголттой, идэвхтэй бэхлэгээтэй, polyurethane, silicone холимог бүрхүүлтэй, электродын оролт IS1 стандарттай, электродын уртын тэмдэглэгээтэй, стеройдын хэсэгтэй, хөдөлгөөнгүй болгож бэхлэхэд зориулсан бэхлэгээ хийх хамгаалалтын хэсэгтэй, биполяр туйлтай байх.	2
3	Ховдлын электрод		Шулуун хэлбэртэй, бүтэн биеийн MRI (1.5T ба түүнээс дээш) хийх боломжтой, хэмжээ 6F-ээс ихгүй, 58 см доод тал нь 4 төрлийн уртын сонголттой, идэвхтэй бэхлэгээтэй, polyurethane, silicone холимог бүрхүүлтэй, электродын оролт IS1 стандарттай, электродын уртын тэмдэглэгээтэй, стеройдын хэсэгтэй, хөдөлгөөнгүй болгож бэхлэхэд зориулсан бэхлэгээ хийх хамгаалалтын хэсэгтэй, биполяр туйлтай байх.	2
4	Электродын хатгалтын интродюсер /ширхгээр/		Гүний венийн хатгалтын зүү, тариур, чиглүүлэгчийг багтаасан багц байх, тэлэгч нь интродюсертэй тогтвортой бэхлэгдэх түгжээтэй, 6F, 7F, 8F, 10F, 11F, 12F өргөний сонголттой, 14 см урттай, урагдан салдаг байх.	4